

## **ОХУ-ЫН “ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРҮҮД” НИЙГМИЙН ТУЛГАМДСАН АСУУДЛЫГ ШИЙДЭХ НЭГ АЛХАМ БОЛОХ НЬ**

*К.Дэмбэрэл\**

ОХУ-ын Ерөнхийлөгчийн зүгээс 2005 оны 09 сарын 05-нд санаачилсан энэхүү “нийгмийн” гэсэн тодотголтой хөтөлбөрийг хэр үндэслэлтэй, хэрэгжих боломжийн хувьд хэр байх талаар энэ өгүүлэлдээ авч үзэхийг зорилгоо.

Орос улс нь хөгжлийн шинэ шатанд орох үед зоригтой, эрс шийдэмгий, далайцтай алхмуудыг хийх үзэл санаа, төлөвлөгөө хэрэгцээ шаардлага урган гарч ирдэг.

XIX-XX зууны зааг дээр Транссибирийн төмөр замыг барьж байгуулахад ч тийм хэрэгцээ бий болсон. “ГОЭЛРО” буюу Орос орныг цахилгаанжуулах төлөвлөгөөг бүр “Зөвлөлт засаг дээр цахилгаанжуулалтыг нэмбэл коммунизм” гэсэн тодорхойлолтоор хэрэгжүүлж байлаа. Сибирь, Алс Дорнодын бүсийн үйлдвэрлэх хүчнийг хөгжүүлэх тухай Бүх Холбоотын бага хурлыг зохион байгуулж байсан 1940-1950-иад онуудад ч ялгаагүй тийм алхам хийж байсан.

Зөвлөлт засгийн үед явуулж байсан “нийгмийн” шинжтэй бодлогууд нь хүнийг жинхэнэ утгаар нь хөгжүүлэхэд бас учир дутагдалтай байсан. Энэ ч утгаараа ЗХУ, түүнийг залгамжлагч ОХУ-д “нийгмийн” чиглэлийн олон асуудал хуримтлагдсан. Эдгээр асуудал зах зээлийн харилцаанд шилжсэн шилжилтийн жилүүдэд улам ихээр нэмэгдэн бүр улс орны аюулгүй байдалд нөлөөлөх хэмжээнд хүрчээ. Тиймээс “нийгмийн” асуудлаа хэр оновчтой, түргэн шийдэхээс цаашдын хөгжлийн асуудал ч шалтгаалах болсон. Ийнхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндсэн шаардлага бий болсоор урсан.

Тухайлбал, ойрын ирээдүйд дэлхий хэмжээний нэг чухал асуудал бол хүний нөөцийн төлөөх глобал хэмжээний өрсөлдөөн юм. Өнөөгийн ОХУ-ын ажиллах хүчний хэрэгцээг хангахад хуучин Зөвлөлтийн бүрэлдэхүүнд байсан БНУ-удын хүн амын ердийн өсөлтөөр хангаж чадахгүй юм. Тиймээс Үндэсний хөтөлбөрийн гол зорилго бол хүнийг тогтвор сууршилтай ажиллуулах бүх нөхцлийг хангах, ингэснээр гадагш чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг бууруулах явдал. Одоогийн нөхцөлд ОХУ нь жил тутам 500-700 /ОХУ-ын Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны мэдээлэл/ мянган мэргэжилтэй боловсон хүннээ гадагш алдаж байна. Энэ нь яваандаа улс орны ирээдүйд “цэг тавихад” хүргэнэ гэсэн үг.

\* К.Дэмбэрэл - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

Хэдийгээр энэхүү Үндэсний хөтөлбөр нь тодорхой нэгэн бүтээн байгуулалт, тухайлбал, БАМ, Транссибирь, ГОЭРЛО гэх мэтийн бүтээн босголтод шууд чиглэгдээгүй ч дэвшүүлсэн санаа нь бол “нийгмийн салбар” гэсэн нэг объектыг бүхэлд нь шинэ түвшинд гаргахад чиглэгдэж байгаа болно.

ОХУ-ын гадаад, дотоод бодлогын тогтвортой байдал, түүний экспортын бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнийн өсөлт, валют санхүүгийн зохистой бодлого, дотоод нөөц бололцоо зэргийг харгалзан үзээд Ерөнхийлөгчийн зүгээс улсын хэмжээнд эрүүлийг хамгаалах, боловсрол, орон сууцны асуудлыг цогцоор нь үндэсний хэмжээнд шийдэхийн эхлэл хэлбэрээр Үндэсний хөтөлбөр боловсруулах үүргийг Засгийн газарт өгсөн. Эдгээр хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай эхний санхүүжилтыг 5 тэрбум ам.доллар байхаар ч заасан.

Дэлхийн их наймтай зэрэгцэн “асуудлаа ярьдаг” төдийгүй улс төрийн тавцанд нөлөө бүхий ОХУ нь дотооддоо “нийгмийн” салбар нь “асуудалтай” байх нь тухайн улсын статуст үл нийцэх зүйл байх нь мэдээж. Хамгийн энгийн үзүүлэлт гэхэд л дараахи зүйлүүдээр түүнийг тодорхойлж болно.

- ОХУ нь байгалийн хий, нефть олборлож экспортлогч гол орны нэг.
- Улс төрийн харьцангуй тогтвортой нөхцөл байдал үүссэн.
- Шинжлэх ухаан, боловсролын өндөр түвшин
- Цэрэг, улс төрийн хувьд дэлхийн тэргүүлэгч гүрний нэг

### **Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд эерэгээр нөлөөлсөн хүчин**

#### **зүйлүүд:**

1. Макро эдийн засгийн тогтворжилт
2. Гадаад өрийг төлж барагдуулсан
3. Төсвийн орлогын нэмэгдэлт
4. Чечений асуудлыг зохицуулсан
5. Төрийн механизмын бэхжилт
6. Гадаад нэр хүндийн өсөлт

XX зуунд ЗХУ болон түүнийг залгамжлагч ОХУ-д хүн рүү бус баялаг руу чиглэгдэж ирсэн томоохон хөтөлбөрүүд нь энэ удаа нийгмийн салбарын доголдлыг “олж харжээ”. Тиймээс Үндэсний хэмжээний хөтөлбөр хэрэгжүүлэх бодит нөхцөл ч зохих хэмжээнд бүрдсэн.

Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтын талаар Ерөнхийлөгч, Засгийн газар, Төрийн думын зүгээс доорхи тоог өгүүлж байна. Ерөнхийлөгч В.В.Путин хөтөлбөрийг анх дэвшүүлэхдээ эхний ээлжийн санхүүжилтэд 5 тэрбум гаруй ам.доллар буюу 180 тэрбум рубль оруулна хэмээн амласан үүнээс 138 тэрбум рублийг Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төрөөс буюу улсын

нэгдсэн төсвөөс гаргах ба үлдсэн хэсгийг төсвөөс гадуур бүрдүүлэх боломжтой гэж үзсэн. Үндэсний хөтөлбөрийг хариуцсан Засгийн газрын нэгдүгээр орлогч Д.Медведевийн ярьснаар 180 тэрбум рублийг улсын нэгдсэн төсөвт суулгасан аж. ОХУ-ын Төрийн Думын хөдөлмөр, нийгмийн бодлогын байнгын хорооны дарга А.Исаевын мэдэгдсэнээр 2006 оны улсын төсөвт Үндэсний хөтөлбөрт зориулан 160 тэрбум рубль “суулгасан” гэнэ. Харин Засгийн газрын орлогч А.Жуковын мэдээллээр бол 2006 оны улсын төсөвт Үндэсний хөтөлбөрт зориулан 116 тэрбум рубль “суулгасан” гэнэ. Үүнээс үзэхэд санхүүжилтийн асуудалд бүх түвшинд нэгдмэл байр суурьгүй байгаа ба хөрөнгө оруулалтын эх сурвалжийн талаар тодорхой зүйлгүй байна.

“Үндэсний хөтөлбөр” хэмээх нэртэй “нийгмийн” хэмээх тодотголтой энэхүү томоохон төслийг салбар бүрээр нь, зарцуулагдах санхүүжилтийг илүү тодруулж үзье.

1. чанартай боловсрол
2. орчин үеийн эрүүл мэндийн хамгаалалт
3. боломжийн орон сууц
4. үр ашигтай хөдөө аж ахуй

Чухамхүү эдгээр 4 салбарыг тухайлбал, эрүүл мэнд, боловсрол, ХАА, орон сууц нийтийн аж ахуйг үндэсний хөтөлбөрийн үндсэн салбар хэмээн үзэж 2006 оны улсын төсөвт түүнийг хэрэгжүүлэх зорилгоор 116 тэрбум рубль буюу 4 тэрбум ам.долларыг тусгасан. Ингэснээр боловсролын салбарт 30 хувь буюу 22 млрд, ХАА-д зориулсан нийт зардал 30 хувь буюу 14.2 млрд рубль, эрүүл мэндийн салбарын зардал 60 хувь буюу 57.9 млрд рубль, орон сууцны салбар 4 дахин буюу 21.9 млрд рубль энэ оны төлөвлөсөн төсөвт нэмэгдэх болоод байна. Энэ нь Засгийн газрын албан ёсны тооцоо.

“Боломжийн орон байр” үндэсний хөтөлбөрт өнөөгийн 20 гаруй тэрбум рублийн зориулалтад нэмээд 100 тэрбум рублийн улсын баталгааг гарган шууд зардал хэлбэрээр өсгөхөөр төлөвлөөд байгаа. ОХУ-ын хувьд нийт хүн амаа европын стандартын хэмжээнд орон байраар хангахад 200 сая кв.м талбай бүхий орон сууц ашиглалтад оруулах шаардлагатай байгаа. ОХУ-ын нийт хүн амын 2/3 нь өөрийн орон байрны нөхцөлд сэтгэл дундуур байдаг.

“Эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр нь улсын хэмжээнд эрүүл мэндийн салбарт түүхэнд байгаагүй томоохон төсөл бөгөөд урьд нь Оросын төрийн бодлогод эрүүл мэндийн салбар хэзээ ч голлох салбар байгаагүй билээ. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх эхний хоёр жилд 145 тэрбум рублийг зарцуулахаар төсөвлөсөн. Эдгээрээс 30 тэрбум рублийг

хэсгийн эмч, сувилагч, түргэн тусламжийн ажилтнуудын цалинг нэмэгдүүлэхэд, 30 тэрбум рублийг анхны тусламжийн оношилгооны баазыг шинэчлэхэд тус тус гаргахаар болсон. Төсөлд бүсийн оношилгоо, эмчилгээний 15 төвийг шинээр барих буюу одоо ажиллаж буйг нь шинэчлэхээр тусгасан. Түргэн тусламжийн 12000 автомашин худалдан авахаар заагдсан. Шинжээчид эрүүлийг хамгаалахыг бэхжүүлэх арга хэмжээг зөв зүйтэй зүйл хэмээн дүгнэж байгаа.

“ХАА-н үйлдвэрлэлийн хөгжил” үндэсний хөтөлбөрт МАА-н хөгжил, ХАА-д жижиг, дунд үйлдвэрийн хөгжлийг голлон анхаарч байгаа. Оросын хувьд туслах аж ахуй, жижиг дунд бизнесийн салбар нь махны 50%, хүнсний ногооны 80%, төмсний 90%-ийг хангадаг хэдий ч төрийн зүгээс “анхаарал халамжийг” зохих ёсоор үзүүлж байсангүй.

“Боловсрол” үндэсний хөтөлбөрт багш сурган хүмүүжүүлэгчид нэн ялангуяа анги удирдсан багш нар, эрдэмтэд, сурган хүмүүжүүлэгчдийн цалинг бодитой нэмэгдүүлэхээс гадна, Москва, Санкт-Петербургт дэлхийн стандартыг хангасан бизнес-сургууль байгуулах, Өмнөд болон Сибирийн холбооны тойрогт үндэстний 2 их сургууль байгуулах, сургалтын хөтөлбөрийг шинэчлэх арга хэмжээг грант хэлбэрээр санхүүжүүлэх ба ингэснээр 30 их дээд, 6000 дунд сургууль үнд хамрагдах боломжтой болно. Боловсролын чанарыг дээшлүүлэх нэг алхам бол ерөнхий боловсролын сургуулийн тэргүүний багш нарт мөнгөн урамшуулал олгох явдал. Боловсролын шинэчлэл хөтөлбөр хэрэгжүүлэх, дээд боловсролын газруудад төсвийн нэмэлт хөтөлбөр, шинээр их сургууль, бизнес сургууль байгуулах, боловсролыг мэдээлэлжүүлэх, авъяаслаг залуучуудыг дэмжих, анги удирдсан багш нарт нэмэлт шагнал бий болгох (1000 хүртэл рубль) 2006 оноос эхлэн жил бүр 10000 хүртэл тэргүүний багш нарт 100000 рублийн (30 гаруй мянган ам.доллар) хэмжээний мөнгөн урамшуулал олгохоор болсон.

Хөтөлбөрт тусгагдснаар бол 2008 он гэхэд орчин үеийн технологид тулгуурласан иргэдэд үзүүлэх эмнэлгийн үйлчилгээ өнөөгийн түвшнээс 4 дахин өсөх боломжтой аж. 2006 оны эхэн гэхэд хэсгийн эмч, хүүхдийн эмч, дотрын эмч нарын сарын цалинг 300 ам доллараас дээш, сувилагч нарын цалинг 170-180 ам.доллараас дээш байхаар хөтөлбөрт тусгасныг энэ оны эхээр хэрэгжүүлж эхэлсэн. Харин 2006-2008 онуудад эрдэм шинжилгээний ажилтнуудын сарын дундаж цалин 1000 ам.доллараас давж байхаар тусгагдсан.

2006 онд Үндэсний хөтөлбөрүүдийн санхүүжилтэд зориулсан тооцооноос харахад тухайн жилийн ХАА, боловсролын салбарын зардлыг 30 хувь, эрүүлийг хамгаалах зардлыг 60 хувь, орон сууц,

түүний дэд бүгшийн хөгжлийн зардлыг 4 дахин тус тус нэмэгдүүлж байгаа аж. Үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зөвлөлийн даргаар Засгийн газрын нэгдүгээр орлогч Д.Медведевийг томилсон ба тэрээр урьд нь Ерөнхийлөгчийн тамгын газрын даргаар ажиллаж байсан. Шинжээчдийн үзэж буйгаар бол Үндэсний хөтөлбөрийг хэр удирдан зохион байгуулж хэрэгжүүлэхээс түүний хувьд ОХУ-ын гурав дахь ерөнхийлөгчид өрсөлдөх эсэх нь шалтгаалах том сорилт аж.

### Дүгнэлт

Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх асуудал хэр бодитой вэ? Төслийн санаачлагчдын зүгээс хэрэгжүүлэх арга замаа тодорхойлохдоо “олон нийтийг хамарсан, нээлттэй” байх зарчим баримтлавал хэрэгжүүлэх бүрэн боломжтой зүйл. Харин тооцоо судалгааг бүрэн гүйцэд хийхгүй, уриа лозунг, нэр хүндээ нэмэгдүүлэх зорилгоор хандвал Хөтөлбөр хэрэгжих боломжгүй. Үндэсний хөтөлбөрийг эхлэхдээ санаачлагчдын зүгээс хөнгөн хандсан тал бий. Тухайлбал, Путин хөтөлбөрөө 9 сарын 5-нд дэвшүүлсэн бол ерөнхий сайд Фрадков хөтөлбөрийн үндсэн санааг тусгасан 25 даалгаврыг /зааврыг/ танхимын бүх сайдууддаа хүргүүлсэн. Хариуг хагас сарын дотор, эцсийн хугацааг 1.5 сарын дотор ирүүлэхийг үүрэг болгосон. Өөрөөр хэлбэл, 1.5 сарын боловсруулсан тооцоо хэр л үндэслэлтэй байх бол.

Оросын хувьд үндэсний хэмжээний хөтөлбөр гэдэг бол шинэ зүйл биш. ХХ зуунд гэхэд бүх нийтийг цахилгаанжуулах, аж үйлдвэржүүлэх, сансрыг эзэмших гээд олон хөтөлбөр амжилттай хэрэгжиж түүнийг бүхэлдээ шинэчлэн дэлхийн манлайлагч гүрэн болгосон билээ. Энэ утгаараа иргэн бүрээс хүчин чармайлт шаарддаг төдийгүй тэдэнд эргээд үр өгөөжөө өгдөг тийм л бүтээн байгуулалт байсаар ирсэн. Тиймээс Хөтөлбөрийг хэрэгжүүлэх эдийн засгийн бүрэн үндэслэл бүрдээд байгаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндсэн хариуцлагыг Засгийн газарт ноогдуулсан бол, ерөнхий хяналтын асуудлыг Ерөнхийлөгчийн хяналтын газарт тус тус ноогдох боллоо.

Үндэсний хөтөлбөрийг Ерөнхийлөгчийн зөвлөл хариуцах ба Ерөнхийлөгчийн зүгээс шууд хянахаа ч амласан. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хянах электрон хяналтын систем ч бий болгохоор болсон.

Тиймээс хөтөлбөрийн хэрэгжилтийн асуудал “жинхэнэ” утгаар явах уу аль эсвэл цаасан дээр үлдэх үү гэдэг нь Засгийн газар цаашлаад Ерөнхийлөгчийн нэр хүнд, үүрэг хариуцлагатай шууд холбоотой.